

СОЦИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР ХАЯНХЯРВААГИЙН ГҮНДСАМБУУ  
(1951-2006)

Ц.Болд

МУИС, ШУС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхим

Orcid: 0000-0002-5765-4254

Ч.Тамир доктор, дэд профессор,

МУИС, ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын захирал

Монголд марксист социологи үүсч хөгжиж эхэлснээс хойш хагас зуун жил, МУИС-д Социологийн тэнхим байгуулагдаж Социологич мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш 30 гаран жил өнгөрчээ. Доктор Х.Гүндсамбуу нь ШУА-ийн Социологийн хэлтэсийн анхны ажилтнуудын нэг төдийгүй, МУИС-ийн Социологийн тэнхимийн анхны багш нарын нэг байв. Түүний амьдрал, эрдэм шинжилгээ, судалгаа бүтээл, өгүүлэл нийтлэлүүд нь дээрх институтүүдийн хөгжиж ирсэн түүхтэй нягт уялдаатай төдийгүй Монголын социологийн шинжлэх ухааны хөгжилтэй салшгүй холбоотой ажээ. Х.Гүндсамбуу монголын социологийн шинжлэх ухааны анхны докторын (Sc.D) хувьд ч монголын социологийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан хувь нэмрийн хувьд ч Монголын социологийн ноён оргилуудын нэгд зүй ёсоор тооцогдох билээ.

Доктор Ц.Пүрэв, А.Жамбал нар нэрт эрдэмтэн Хандын Нямбуугийн намтар (Ц.Пүрэв, 2012) бүтээлийг тоймлон бичихдээ «Эл нэрт эрдэмтний намтар, эрдэм судлалын ажил, уран бүтээл өнөө хүртэл зохих хэмжээнд зориудаар бүрэн судлагдаагүй байна» хэмээн онцолсон нь бий. Түүнтэй ялгаагүй, Монголын социологийн шинжлэх ухааны ноён оргилуудын нэг Хаянхярваагийн Гүндсамбуугийн намтар, эрдэм судлалын ажил, бүтээл туурвилыг өнөө хэр даацтай судалж, түүний бүтээлийн царраа, шинжлэх ухаан тэр дундаа Монголын нийгмийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан хувь нэмэр, үр нөлөөг зохих ёсоор үнэлж хараахан чадаагүй байна. Ядуу малчны хүүхдээс ШУА-ийн ФСЭХ-ийн Социологийн секторын эрхлэгч, МУИС-ийн дэд профессор, Социологийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэгт хүрсэн түүний зам мөр нь баялаг хийгээд халгиа цалгиатай, тэр хэрээр өгөөжтэй мөлжүүртэй.

Түүний талаар, «Хорьдугаар зууны Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага» хэмээх гайхамшигтай бүтээлийнхээ ард бичиж оруулсан товч танилцуулга, Х.Ариун-Эрдэнэ -ийн эмхэтгэн хэвлүүлсэн “Сүхбаатар аймгаас төрсөн эрдэмтэд”<sup>1</sup> номонд орсон товч намтар болон МУИС-ийн архивт хадгалагдан үлдсэн намтараас өөр баримт материал төдийлөн олдохгүй байна. Гэхдээ бичиж хэвлүүлсэн ном бүтээл, өгүүлэл нийтлэлүүд нь зохиогчийнхоо талаар багагүй мэдээллийг өгдөг юм.

Хаянхярваа овогтой Гүндсамбуу нь 1951 оны хоёрдугаар сарын 22 -ны өдөр, одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг «Ар хөөвөр» гэдэг газарт малчин Олзодын Хаянхярваагийн ууган хүү болж мэндэлжээ. Тэрээр «Егүзэр хутагтын экологийн менежмент» номдоо, “...*«Хатгин овгийн нүүдэлчин, харц язгуурт Дамдинсүрэн» хэмээн шүлэглэсэн ...академич Ц.Дамдинсүрэн гуай бол манай зэргэлдээх Матад сумынх. Дээр үед одоогийнх шиг аймаг сум баг гэсэн засаг захиргааны хуваарь байсангүй, овог л байсан. Зотол хаан, Матад хаан, Дархан хаан гурван уул хатгиных*”<sup>2</sup> хэмээн бичсэн нь бий. Тэгэхээр Гүндсамбуу багш хатгиных болж таарах нь. Гэхдээ өөрийн ургийн овгийг “Хавхчин” гэдэг юм.

Х.Гүндсамбуу хүү найман нас хүрээд “алаг морио унаж ааваараа хүргүүлэн” Зотол<sup>3</sup> сумын бага сургуульд алхан оржээ. Ийнхүү 1959 онд Зотол сумын бага сургуульд элссэн бол бага сургуулиа төгсөх үед сургууль нь Эрдэнэцагаан сумын сургууль гэж нэрлэгдэх болсон байлаа. 1959-1967 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын бага, дунд сургуульд суралцаж бүрэн бус дунд боловсрол

<sup>1</sup> Х.Ариун-Эрдэнэ, “Сүхбаатар аймгаас төрсөн эрдэмтэд”, СБ.,2007, 104-107-р тал, “Улс төрийн академийн багш асан, Социологийн шинжлэх ухааны доктор, профессор Хаянхярваагийн Гүндсамбуу (1951-2007)”

<sup>2</sup> Х.Гүндсамбуу, «Егүзэр хутагтын экологийн менежмент», УБ.,2000.

<sup>3</sup> 1942 онд Зотол болон Урт сумдыг Дорнод аймгаас шилжүүлж шинээр байгуулагдсан Сүхбаатар аймагт (анх Жавхлант шарга нэртэйгээр байгуулагдсан) харьяалуулсан байна. 1961 онд хоёр сумыг нэгтгэн Эрдэнэцагаан гэж нэрлэжээ (Сумын тухай танилцуулга, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын албан ёсны вэб хуудас)

эзэмшээд, 1967-1969 онд Баруун-Уртын 10 жилийн сургуулийг дүүргэн бүрэн дунд боловсролтой болсон байна.

Залуу Х.Гүндсамбуу 1969-1974 онд МУИС -ийн барилгын эдийн засгийн ангид суралцаж, 1974 оны 6-р сарын 29-ны өдөр 8229 бүртгэлийн дугаартай, 20320 тоот дипломтой, “барилгын эдийн засаг зохион байгуулагч”<sup>4</sup> мэргэжилтэйгээр сургуулиа төгсчээ.

#### **Эрдэм шинжилгээний ажилтан болсон нь**

Х.Гүндсамбуу их сургуулиа төгсөнгүүтээ, 1974 оны 7-р сарын 15-наас, байгуулагдаад удаагүй байсан шинэхэн хүрээлэнгийн Социологийн секторт ажилд орж, эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан болсон байна.

Шинэхэн хүрээлэн гэхийн учир нь, “МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1972 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 193 дугаар тогтоолоор, «Философи, социологи, эрхийн хүрээлэн байгуулах тухай» шийдвэр гарчээ”<sup>5</sup>. “ШУА-ийн Ерөнхийлөгчийн 1973 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 153 дугаар тушаалаар Социологийн хэлтсийн эрхлэгчээр Х.Нямбуу томилогдож, албан ёсоор ажил үүргээ эхэлсэн байдаг”<sup>6</sup>.

ФСЭХ-ийн Социологийн секторт “1973 оны 1 сард Р.Вандангомбо, С.Гомбо, Ц.Дагвадаш, Ц.Уртнасан нар, 9 сард С.Дашдаваа, Р.Каусыл нар, 1974 онд Х.Гүндсамбуу, 1975 онд Я.Мөнхжаргал, Ц.Пүрэв нар эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтнаар орсон ажээ...”<sup>7</sup>

Ц.Уртнасан, С.Гомбо нарын анхдагчдыг, академийн архагууд болох академич Б.Ширэндэв, профессор Д.Дашжамц, академич С.Норовсамбуу, академич Ч.Жүгдэр нар сонгож шийдэж авсан бол Х.Нямбуу багш эрхлэгч болсныхоо дараачаар ажилд авсан анхны ажилтнууд нь С.Дашдаваа, Х.Гүндсамбуу нар болсон аж. Дээр нь математикийн багш мэргэжилтэй Ц.Пүрэвийг 1975 онд нэмж авснаар түүхч+философич+инженер+эдийн засагч+математикч гэсэн бүрэлдэхүүнтэй Х.Нямбуу багшийн удирдлага доорх Социологичдын баг бүрдэж эхэлсэн байна. Х.Нямбуу багш болон хашир академичид маань социологид математик, эдийн засаг, инженерийн боловсролтой мэргэжилтэн шаардлагатай гэж тооцож Х.Гүндсамбуу багш, С.Дашдаваа багш, Ц.Пүрэв багш нарыг багтаа нэгтгэсэн болов уу.

Тухайн цаг үед социологид инженерийн болон эдийн засгийн суурь мэргэжилтэй гурван хүн орж ирсэн нь С.Дашдаваа, Х.Гүндсамбуу, Д.Ганхуяг нар билээ. Түүнчлэн математикч мэргэжилтэй гурван хүн орж ирсэн нь В.Отгоннасан, С.Төмөр-Очир, Ц.Пүрэв нар юм. Харин Х.Гүндсамбуу эдийн засагч мэргэжлээ огтхон ч хаяагүй, түүний мэргэжлийн карьер нь эдийн засагч - түүхийн социологич - нийгмийн бүтцийн социологич - улс төр судлаач - эдийн засгийн социологич гэсэн схемээр явсан юм.

Х.Нямбуу багшийн удирдлага дор, сургуулиа төгсөөд тун удаагүй байсан шижигнэсэн залуучууд цуглаж, шинэ баг хамт олон бүрдэж эхэлжээ. Шинэ хамт олон бүрдэж эхлэхтэй хамт Монголд Социологийн шинжлэх ухаан үүсэн бүрэлдэх, хөгжих явц зэрэгцэж, Монгол дахь Социологийн шинжлэх ухааны нэгэн тулгуур, мэдлэгийн төв цэцэглэж эхэлсэн гэж хэлж болно. Социологийн секторын түүхийг бичилцэж эхэлсэн анхдагчид, Монгол дахь социологийн анхны судалгаануудыг хийж хэрэгжүүлж эхэлсэн баг хамт олон нь дээрх бүрэлдэхүүн байсан гэхэд буруудахгүй байхаа. Тиймээс Х.Гүндсамбуу бол Монголын Социологийн анхдагчдын нэг, Монгол дахь социологийн судалгааны анхны шанг таталцсан судлаач эрдэмтэн мөн билээ.

#### **Инженер эдийн засагчаас социологич болсон нь**

1974 оны 7-р сарын 15-наас эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтнаар ажлын гараагаа эхэлсэн бол, аспирантурт элсэж эрдэм шинжилгээний ахлах ажилтан хүртэл дэвшин ажиллаж байгаад, дэд эрдэмтний зэрэг хамгаалсныхаа дараахан, 1988 оны 9-р сарын 30-аас “Социологийн секторын эрхлэгч”-ээр томилогдож, 1990 оны 9-р сарын 22 хүртэл ажиллажээ. Х.Гүндсамбуу ФСЭХ-ээс ажлынхаа гарааг эхлэхийн зэрэгцээ, инженер эдийн засагчаас социологич болж хөрвөх, хос мэргэжилтэй болох, мэргэшсэн судлаач, эрдэмтэн болох замналаа эхэлсэн байна. Түүний

<sup>4</sup> МУИС-ийн албан ёсны вэб хуудас, төгсөгчдийн мэдээлэл, <https://www.num.edu.mn/files/tugsugch/diplom/1974.pdf>

<sup>5</sup> Ж.Амарсанаа, А.Жамбал, “Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн байгуулагдсан хийгээд түүний үүсэл, хөгжилд академич Чимидийн Жүгдэрийн бүтээсэн гавьяат үйлс”, - «Философи эрхийн судлал», ХХҮИ боть, УБ.,2012.

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> Ред. Ц.Уртнасан нар, «Монгол дахь социологийн хөгжил», УБ.,2011.

судлаачийн хийгээд эрдэм шинжилгээний ур чадвар, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, дүрслэн бичих, нийтлэх ур чадвар, судалгааны сонирхол, хөндөж судалсан сэдэв бүгд социологийн секторт ажиллаж байсан энэ цаг үе, тэнд хамт ажиллаж байсан эрдмийн нөхөд, хүрээлэнгийн удирдлагуудтай салшгүй холбоотой билээ. Гүндээ багш өөрөө “багцын онол” гэж их ярина. Социологийн секторын анхдагчид чухам тэрхүү багцын нэг мөн буюу.

Х.Гүндсамбуу нь 1977 оны 11-р сарын 1-нээс гурван сарын хугацаатайгаар ЗХУ-ын Москва хотод ШУА-ийн Социологийн судалгааны Институтад мэргэжил дээшлүүлжээ. 1975 оны 3-9 сард С.Гомбо, С.Дашдаваа, Ц.Дагвадаш, Х.Нямбуу, Ц.Төрбилэг, Ц.Уртнасан нарын өргөн бүрэлдхүүнтэйгээр ЗХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэн дээр 6 сарын хугацаанд мэргэжил дээшлүүлснийг Монголын социологичдын бэлтгэгдсэн гурав дахь давалгаа гэж тооцвол Х.Гүндсамбуу дөрөв дэх давалгаанд хамрагдсан бололтой. Бүр сүүлд, арван жилийн дараагаар 1987 оны 11-р сарын 15-наас 1988 оны 1-р сарын 6-ны хооронд ЗХУ-ын Москва хотод ШУА-ийн Социологийн Судалгааны Институтад 45 хоногийн хугацаатайгаар дахин мэргэжил дээшлүүлсэн байдаг.

Бусад үед хамтран ажиллагсаасаа харилцан суралцаж, ажиллангаа, судлангаа, талбарын судалгаандаа суралцаж мэргэшсэн байдаг. Гэхдээ энэ нь тэднийг, өөрсдийгөө шогчлон тодорхойлдогчлон “партизаны социологичид” юм уу зөвхөн практикийн мэргэжилтнүүд гэж дүгнэх үндэслэл болохгүй билээ.

ЗХУ-ын ШУА-ийн Социологийн Хүрээлэн, БНПАУ-ын ШУА-ийн Социологийн Хүрээлэн (тухайн үеийн нэрээр) зэрэг социалист орнуудын хүрээлэнгийн эрдэмтэд, судлаачид байн байн ирж, хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлж, санал бодлоо солилцдог, онол арга зүйн мэтгэлцээн хийдэг, хурал симпозиум ч зохиодог байлаа.

Тухайн үед шинээр эхэлсэн томоохон суурь судалгаануудад социологийн секторынхон бөөнөөрөө олон хоногоор явцгаадаг байж. Голчлон малчдын нийгмийн асуудал, хоршоолсон малчдын асуудал, саальчдын хөдөлмөр зохион байгуулалт, хөдөөгийн иргэдийн соёлын асуудал, аж байдал гэхчлэн сэдвээр малчны хотонд судалгааны ажил үргэлжилнэ. Энэ бүхэн нь хүрээлэнгийн социологичдыг улам ойр танилцуулж, талбарт ажиллангаа суралцах боломж, завшаан байсан байна. Доктор Ц.Уртнасан дурсамждаа, *«Гүндээ, хөдөөгийн амьдралыг маш сайн мэднэ, судлагдагсад хонь ямаа сааж, самнаж байвал тэр болгоныг нь хамт хийж байгаад л мэдээллээ цуглуулчихна. Хүмүүстэй ямар ч сэдвээр яриа өрнүүлчихнэ, бараг цаанаасаа социологич болох ёстой хүн байсан байх»* хэмээн онцолсон байдаг. Хурга хөнгөлөх цагаар айлын хоолон дээр таарч, тогоо дүүрэн хурганы засаанаас Ц.Дагвадаш, Х.Гүндсамбуу хоёр амаа олохгүй идэж, хотод өссөн хэд нь идэж чадалгүй хоолгүй хоцорсон<sup>8</sup> гээд л хууч яриа хөвөрнө. Олон хоног хөдөө явахар бөөстөх хуурстах үе ч тохиолддог байж. Судлаач Д.Ганхуяг “Бөөстөж үзээгүй социологичийг ямар социологич гэдэг юм” гээд инээгээд байдаг юм. Энэ бүхэн тэдний социологич болж мэргэших төлөвшихөд нөлөөлсөн нэг хүчин зүйл болсон байдаг.

Доктор С.Дашдаваа нэгэнтээ, *«хүрээлэнгийн хэмжээнд зургаа дахь өдөр болгон явагддаг “Онол арга зүй”-н семинар бидний мэргэжил дээшлүүлэх, ер нь тасралтгүй суралцаж байхад их чухал үүрэг гүйцэтгэж байсан»*<sup>9</sup> хэмээн дурссан нь бий. Энэ семинар дээрээ дориухан мэтгэлцдэг, заримдаа ч нэлээн ширүүн маргалддаг байсан гэдэг. Тэр болгонд секторын эрхлэгч доктор Х.Нямбуу болон хүрээлэнгийн захирал академич Ч.Жүгдэр нар маргааныг тасалж, хоёр талыг “номхруулж”, зөвлөнгөө сургадаг байсан байна.

1973 оны 1 сараас 1974 оны 7 сар хүртэл, хоорондоо нэг жил 6 сарын хугацаатай цувран ажилд орцгоосон социологичид, бие биенээ “шинэков” гэж нэр хоч зүүцгээдэг, оны ялгаа гаргадаг байсан ч социологичийн хувьд бүгдээрээ л “шинэков” байжээ, тэр үедээ. “Шинэковууд” 1976 оны 12 сарын 14 нд Хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар 1976 оны ажлын тайлангаа хэлэлцүүлээд, Ц.Уртнасан, С.Гомбо, Р.Вандангомбо, Ц.Дагвадаш, С.Дашдаваа, Х.Гүндсамбуу нар бөөнөөрөө эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтнаас эрдэм шинжилгээний дэд ажилтан болцгоож<sup>10</sup>, хамтдаа “жинхэлсэн” байдаг билээ. Тэд ийнхүү социологич болцгоожээ.

<sup>8</sup> Социологийн секторын анхны социологичдын нэг Ц.Төрбилэгийн дурсамжаас

<sup>9</sup> Пуужингийн инженер С.Дашдаваа. Дурсамжаас

<sup>10</sup> Философийн Хүрээлэнгийн хагас зууны түүхэн товчоон, УБ.,2022, х 242.

## Нийгмийн бүтцийн социологич

Доктор Ц.Уртнасан, «Манай сектор анх байгуулагдаж судлах сэдвээ сонгох үед Нямбуу дарга маань нийгмийн бүтцийн судалгааг барьж авбал бидэнд ирээдүй байна гэж хэлж байж билээ. Үнэхээр ямар холыг харсан, монголын социологийн шинжлэх ухааны үндсэн чиглэлийг тодорхойлсон гэдгийг бид одоо л ухаарч байна»<sup>11</sup> хэмээн дурсамждаа өгүүлсэн байдаг. Социологийн хүрээлэнгийнхэн, хүрээлэн байгуулагдсан цагаас эхлэн нийгмийн бүтцийн чиглэлээр тасралтгүй ажилласан, ажиллаж байгаа, Социологийн хүрээлэнгийн суурь судалгааны үндсэн чиглэлийн нэг нь нийгмийн бүтцийн судалгаа гэж хэлж болно. Түүний эхлэл болгож, шанг татаж “БНМАУ-ын нийгмийн бүтэц” сэдэвт суурь судалгааны ажлыг 1976-1980 онуудад хийж гүйцэтгэжээ. Үүнээс «...ажилчин, малчдын хөдөлмөр, ахуй, гэр бүлийн асуудлыг судлахдаа нийгмийн бүтэцийн асуудлыг Ц.Уртнасан, Х.Гүндсамбуу нар хариуцан авч»<sup>12</sup> ажиллаж, үр дүнг шинжилж тус судалгааны чиглэлийг хөгжүүлсэн юм.

Х.Гүндсамбуу 1982-1985 онд дотоодын аспирантурт суралцаж төгссөн байна. Энэ үе нь Социологийн секторынхон нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээгээ гүнзгийрүүлж, анги, бүлэг болгоноор нь лавшруулан судалж байсан тэр үетэй давхцана. Ц.Уртнасан, Х.Гүндсамбуу нарын судалгааны чиглэл адил, нарийсган шинжлэхээр сонгож авсан нийгмийн бүлгүүд нь ялгамжтай болохоос судлах арга зүй аргачлалын хувьд төдийлөн зөрүүгүй. Ийнхүү ажил мэргэжил, судалгааны чиглэлээрээ холбогдсон ирээдүйн их эрдэмтэд 1990-ээд оныг хүртэл хамтран хоршин ажилласан ажээ. Ц.Уртнасан нь ажилчин ангийн нийгмийн бүтцийн чиглэлээр, Х.Гүндсамбуу хоршоолсон малчдын нийгмийн бүтцийн асуудлаар мэргэшин судалж, тус тусын сэдвийн хүрээнд зарлагдсан дотоодын аспирантурт элссэн ажээ. Удаа ч үгүй дараа дараалан эрдмийн зэргээ хамгаалцгаасан байна\*.

Ц.Уртнасан дурсамждаа, «Улсын төв номын сангийн зүүн тал, Чойжин ламын сүмийн баруухан талд, одоогийн “Нээлттэй нийгэм хүрээлэн”-ийн суурин дээр байсан ШУА-ийн авто гражийн хашаанд 6 айлын модон орон сууц байдаг байлаа. Түүнд Гүндээгээ оруулах гэж сектороороо хөдөлсөн дөө» хэмээн өгүүлжээ. Олон хүүхэдтэй амьдрал ахуйгаа аваад явж байгаа, судалгаа шинжилгээний ажилдаа өсөж байгаа хэмээн нэгнийгээ дэмжиж амьдрах орон сууцтай болгосон нь залуухан судлаач Гүндээгийн хувьд ёстой л завшаан болсон бололтой. Гэрээсээ гараад л номын санд сууж, авсан номнуудаа хураахгүй, дэлгээтэй чигээр нь орхиод гэртээ орж түргэхэн цайгаа уучаад ирдэг, эргээд л номын сандаа ороод суучихдаг байсан гэнэ.

1987 онд Х.Гүндсамбуу нь “БНМАУ-ын хоршоолсон ард ангийн нийгмийн бүтцийн хөгжил, хандлагын асуудал” сэдвээр философийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. Сэдэв нь социологийнх, хамгаалуулсан зөвлөл нь философийнх. Х.Гүндсамбууд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссын 1987 оны 2-р сарын 19-ны өдрийн 03-р тогтоолоор философийн ухааны дэд эрдэмтний зэргийн 87349 дугаартай дипломыг олгожээ. Ийнхүү нийгмийн бүтцийн чиглэлээр мэргэшсэн нь хожим “Хорьдугаар зууны Монголын нийгмийн давхраажилт: хөгжил, хандлага” хэмээх суут бүтээлээ туурвихад нь томоохон түлхэц, бэлтгэл болсон юм.

Доктор Ц.Пүрэв, «Социологийн секторын ажилтнууд 1970 – 1980 -аад онд цуглуулсан анкетаа гараар тоолж боловсруулдаг байлаа. Анкет нь олон асуулттай учраас их зузаан. Гүндээ анкетаа гэртээ аваачиж боловсруулах гээд 70 кг-ын гурилын шуудайн ихэнхээр нь хийгээд үүрээд автобусаар явж байсныг мэдэх юм. Туслах ажилтнууд голдуу тоолж дүн гаргадаг хэдий ч илүү нарийн боловсруулалт хийх, янз бүрээр бүлэглэж, статистик тооцоо хийх гэж тэр шүү дээ» хэмээн дурсамждаа онцолжээ. Эрдэм шинжилгээний туслах ажилтнуудын тоолж гаргасан дүн нь Гүндээ багшийн сэтгэлийг цагтахгүй, судлаачийн шуналыг нь хангахгүй, арай жаахан гүнзгийрүүлсэн боловсруулалт хийх гээд, ядаж харьцуулалт хийх болохоор нөгөөдүүл нь барахгүй. Тухайн үеийн

<sup>11</sup> Доктор Ц.Уртнасангийн дурсамжаас

<sup>12</sup> “Философийн Хүрээлэнгийн хагас зууны түүхэн товчоо”, УБ.,2022, Салбаруудын түүхэн замнал: Социологийн салбар, х.119.

\* Ц.Уртнасан нь 1989 онд “БНМАУ-ын ажилчин ангийн нийгмийн бүтцийн социологийн асуудал” сэдвээр философийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээлээ бичиж, амжилттай хамгаалсан байна.

мэдээлэл боловсруулах хурд боломж тийм л байж. Тэгээд л өөрөө гэртээ аваачиж тоолдог байсан байна.

Доктор С.Дашдаваа, «Би уг нь “Ажилчдын нийгмийн идэвх”, “Малчдын нийгмийн идэвх”, “Сэхээтний нийгмийн идэвх” гэсэн гурван боть бүтээл туурвих зорилготой байсан. Гэвч нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан гүйцээж гаргаж амжаагүй. ...Миний шавь, социологич, доктор (Sc.D) Х.Гүндсамбуутай хамтран “Малчин залуучуудын нийгмийн дүр төрх” 1984 он, “Ажилчин залуучуудын нийгмийн төрх” 1990 гэсэн бүтээлүүдийг хэвлүүлсэн»<sup>13</sup> хэмээн дурсамждаа бичсэн байдаг. С.Дашдаваа багш Х.Гүндсамбуу багшаас насаар хэд ахын хувьд, Социологийн секторт бас ч гэж нэг жилийн өмнө ажилд орсны хувьд, гучаад жил гар нийлж хамтран ажилласны хувьд түүнийг өөрийн шавь хэмээн дурссан байна. Хүрээлэнд байх үеэс судалгааны мэдээллийг боловсруулахад хамтран ажилладаг байжээ. Өөрийн нь дурссанчлан, 1975 онд Москвад мэргэжил дээшлүүлэхдээ С.Дашдаваа, “Социологийн судалгааны онол, арга зүй, арга, техник”-ийн хэлтэст хуваарилагдсан гэдэг бөгөөд тэр үеэс хойш судалгааны арга техникийн хувьд түлхүүр мэргэжилтэн болж, мэдээллийг боловсруулах чиглэлээр манлайлан ажиллах болсон байна. Математикчийн хувьд Ц.Пүрэв, эдийн засагчийн хувьд Х.Гүндсамбуу нар түүний “мэдээлэл боловсруулалтын багт” зүй ёсоор нэгдсэн бөгөөд олон жил үр бүтээлтэй хамтран ажилласан байдаг. Нийгмийн бүтцийн судалгааны арга зүйг хөгжүүлэх явцдаа мэдээлэл боловсруулах аргачлалаа ч зэрэг хөгжүүлж, ажиллангаа бие биенээсээ суралцаж хөгжжээ. Тиймээс, “миний шавь Х.Гүндсамбуу” хэмээн бахархан дурссан болов уу.

Тэрээр эдийн засагч гэсэн суурь мэргэжилтэй, үндсэн мэргэжлээ хаяагүй бөгөөд мөн социологийн чиглэлээр мэргэшсэн нь нийгмийн бүтцийн судалгаа хийхэд бусад социологичдоос ихээхэн давуу талыг түүнд олгосон бөгөөд нийгмийн бүтцийн социологич гэдгээсээ гадна эдийн засгийн социологийн томоохон эрдэмтэн гэдгээрээ олонд танигдсан юм. (Жамбал, 2017)

#### **Давхраажилтын судалгааны шанг татагч**

Доктор Х.Гүндсамбуу, 1994 онд “Шинэ толь” сэтгүүлд хэвлүүлсэн “Өнөөгийн монголын давхраажлын төлөв байдал” өгүүлэлдээ, «*Болхи миний бие эх орондоо социологийн шинжлэх ухааны шавыг тавилцаж, нийгэм-ангийн бүтцийн судалгаагаар дагнан мэргэшсэний хувьд Монголын ангийн давхраажлын судалгааны өрхийг татаж, үүдийг нээ юу гэж зориглосон юм*»<sup>14</sup> хэмээн зарласан байдаг. Энэ нь, “Хорьдугаар зууны Монголын нийгмийн давхраажилт: хөгжил, хандлага” хэмээх гайхамшигтай бүтээл төрөхийн үүтгэл байсан бололтой. Тун удалгүй, 1995 онд болсон Социологичдын анхдугаар симпозиум дээр “Нийгмийн давхраажлыг судлах арга зүйн зарим асуудал”<sup>15</sup> хэмээх илтгэлээр давхраажилтын шалгуур үзүүлэлтийн талаарх санал шүүмжээ хэлж өөрийн дэвшүүлж буй хувилбарыг танилцуулсан байдаг.

Давхраажлын судалгааны шанг татсан гэж өөрийнх нь тодорхойлсон анхны өгүүллээр нь баримжаалахад 1994 оноос эхлээд 2002 он хүртэл лавтайяа 8 жил энэ бүтээл дээрээ ажилласан байна. Нийгмийн бүтцийн судалгаагаар дагнан ажилласан туурвисан жилүүдийг хамруулбал, номынх нь өмнөтгөлд доктор Ш.Түдэвийн “*Олон жилийн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан бичсэн*”<sup>16</sup> хэмээн онцолсон байдагчлан, 20 гаран жилийн эрдэм судлалынх нь үр дүн болсон бүтээл юм.

Нэг талаас Нийгмийн бүтцийн судалгааны бүтээл юм шиг нөгөө талаас түүгээрээ дамжуулж, ХХ зууны Монголын нийгмийн түүхийг бүхэлд нь дүгнэсэн Түүхийн бүтээл шиг. Дандаа нийгмийн бүтцийн асуудал дээрээ төвлөрсөн гэхээсээ илүүтэй, нийгмийн бүлгүүдээр дамжуулж, тухайн үеийн нийгмийн асуудлуудыг задлан шинжилж, уялдаа холбоонд харуулсан байдаг юм. Энэхүү бүтээл нь ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг хөндсөнөөрөө эдийн засгийн социологийн, улс төрийн системийн асуудлыг хөндсөнөөрөө улс төр судлалын бүтээл ч мөн. Олон шинжлэх ухааны огтлолцол дээр салбар дундын асуудлыг багтааснаараа тэр хэрээр зангарагтай, тэр хэрээр оюуны бяд, сэтгэлгээний цараа шаардсан ажил юм.

<sup>13</sup> Пуужингийн инженер С.Дашдаваа. Дурсамжаас

<sup>14</sup> “Шинэ толь” сэтгүүлийн тусгай дугаарт, (№5) хэвлэгдсэн байна. УБ.,1994

<sup>15</sup> Х.Гүндсамбуу (Философийн ухааны дэд доктор), Монголын Социологичдын анхдугаар симпозиум дээр танилцуулсан илтгэл. 1995 оны 12 сарын 26.

<sup>16</sup> Ш.Түдэв, “Хорьдугаар зууны Монголын нийгмийн давхраажилт: хөгжил, хандлага” бүтээлд зориулж бичсэн өмнөх үг.

Х.Гүндсамбуугийн багшийн энэ бүтээлд хөндөгдөөгүй сэдэв, ашиглаагүй материал бараг үлдсэнгүй. Нэг талаас, Монголын социологийн шинжлэх ухааны хөгжлийн түүх ч юм шиг. зарим талаар Монголын социологичдын бүтээлийг дахин REVIEW хийж хольж миксэрдэж базаж дүгнэсэн ч гэж хэлж болохоор. Нийгмийн бүтцийн асуудлаар дагнан бичигдсэн гэхээсээ илүүтэй, нийгмийн бүтцийн загвар дээрээ суурилж, нийгмийн асуудлуудыг бүхэлд нь хамран бичсэн байдаг. Ажилгүйдэл, ядуурал, их хэлмэгдүүлэлт, мал нийгэмчлэл, өмч хувьчлал, мал хувьчлал, оюутны элсэлт төгсөлт гээд хөндөөгүй асуудал байхгүй юм.

Академич Г.Чулуунбаатарын дүгнэсэнчлэн, *«Асуудалд холбогдол бүхий ихэнх баримт мэдээлэлд философи, ерөнхий социологи, улс төрийн шинжлэх ухаан, сэтгэл судлал, эпистемологи, герменевтик зэргийн үүднээс утга тайлал хийж, судлаачийн хувьд үзэл бодол, байр сууриа маш өвөрмөц байдлаар томъёолон илэрхийлсэн байдаг...»*

### **Судалгааны сэдвүүд**

Бидний олж авч тодруулж чадсанаар, анхны өгүүлэл нь 1980 онд хэвлэгдсэн байна. Сургууль төгссөнөөс хойш нэлээн аажуухан бүтээлээ туурвиж эхэлсэн гэж ойлгогдож байна. Тэр үес хэвлүүлж байсан бүтээлүүд нь бүгд л “Нийгмийн бүтцийн асуудлууд” -ыг хамарсан байгаа нь анзаарагдана. 1980 онд, “Барилгачдын оюун санааны зарим асуудал”, “Өнөөгийн нэгдэлчдийн доторх нийгэм-мэргэжлийн бүлгүүдийг тодорхойлох нь” хэмээн нийгмийн зарим бүлгүүдийг тодорхойлох оролдлогууд хийж эхэлсэн бол, 1983 онд “Малчин залуучуудын нийгмийн дүр төрх”, 1984 онд “Хоршоолсон ард”, “Ажилчин залуучуудын нийгмийн дүр төрх” (1990), “XXI зууны босгон дахь монголын залуучууд” (1998), зэрэг өгүүлүүддээ нийгмийн бүлгүүдийг зураглах оролдлогуудаа үргэлжлүүлсээр байсан ажээ. Энэ хугацаанд сурагч, залуучууд, малчин, ажилчин, сэхээтнүүд, боловсрол мэргэжлийн бүлэг, ажил мэргэжлийн үнэлгээ, тогтвор суурьшил, шилжих хөдөлгөөн нийгмийн бодлого, шударга ёс, намын программ зэргийг социализмын нийгэм - ангийн бүтцийн хүрээнд судалж байв. Нийгмийн бүлгүүдийг судлах, танин мэдэх оролдлого нь тасралтгүй үргэлжилсэн юм.

Доктор Х.Гүндсамбуу албан ёсоор багшаа гэж гагцхүү академич Ч.Жүгдэр гуайг л хэлдэг байв. Түүний багштайгаа хийсэн нэг ярилцлага бий<sup>17</sup>. Х.Гүндсамбуу, монголын философи-нийгэм улс төрийн сэтгэлгээний түүхээр мэргэшиж ид ажиллаж байсан түүнээс өөрийн судалгааны ажилтай уялдуулан сонирхолтой ярилцлага хэлбэрээр өөрөө зохиомжлон бичсэн байдаг. Тэр ярилцлагаас өмнө Гүндээ багшийн “Малчин залуучуудын нийгмийн дүр төрх” ном 1984 онд нэгэнт хэвлэгдчихсэн байсан. Гэхдээ л “Залуучуудын асуудлыг судлах шаардлагатай” гэх санааг Жүгдэр багшийн ярилцлагаар дамжуулан олон нийтийн анхааралд татахаар хэвлүүлжээ гэж дүгнэж болохоор санагддаг.

Умаар дурдагдсан ярилцлагын араас залуучуудын талаарх хэд хэдэн цуврал бүтээлийг туурвисан билээ. Тухайлбал, С.Дашдаваа, Х.Гүндсамбуу нар хамтран “Ажилчин залуучуудын нийгмийн дүр төрх” бүтээлээ 1990 онд хэвлүүлсэн. Х.Гүндсамбуу, Г.Чулуунбаатар нар хамтран “XXI зууны босгон дахь монголын залуучууд” бүтээлийг бичиж 1998 онд хэвлүүлсэн байдаг. Дээр дурдсан гурван томоохон бүтээлээс гадна “Залуу хүний амьдралын нэгэн төлөвлөгөө”, “Хүүхэд залуучуудын талаарх төрийн бодлогын тухайд”, “Хүүхдийн нийгмийн асуудал: эргэцүүлэл бодомж” зэрэг асуудал дэвшүүлсэн хэд хэдэн нийтлэлийг бичсэн байдаг.

Дашрамд дурдахад Х.Гүндсамбуу багш өөрийн багш Ч.Жүгдэрийг дагалдаж нийгэм улс төр философийн сэтгэлгээний түүхийг судлах арга зүйг тодорхой хэмжээнд эзэмшсэн. Үүнийг харуулах бүтээл бол Х.Гүндсамбуу, С.Дашдаваа, С.Норовсамбуу нарын “Орчин үеийн шатан дахь БНМАУ-ын социологийн сэтгэлгээний хөгжил” хэмээх орос хэлээр бичигдсэн томоохон бүтээл билээ<sup>18</sup>. Энэ бүтээл монголчуудын социологийн сэтгэлгээний түүхийг анх удаа тусгайлан судалж тоймлон харуулсан бүтээл юм. Өгүүлэл нь “Социалист орнуудын социологийн сэтгэлгээний түүхээс” хэмээх хуучин социалист орнуудын эрдэмтдийн хамтын бүтээлд цөөн хувь хэвлэгдэн гарсан байдаг. Уг

<sup>17</sup> Эрдмийн ертөнцөд хийсэн аян. “Залуучуудын үнэн” сонин “Ням гаригийн” зочин буланд нийтлэгджээ. Ярилцлага хөтөлсөн Х. Гүндсамбуу. 1987 оны 8 дугаар сарын 16, №91 /7368/

<sup>18</sup> Развитие социологической мысли в МНР на современном этапе //Из истории социологической мысли в социалистических странах. Кн I, М., 1988 (Гүндсамбуу, Х., Дашдаваа, С., Норовсамбуу, С., 1988)

бүтээлийг монголоос хайж олоход их төвөгтэй байсан учраас бидний анд Буриад эрдэмтэн Дамдин Бадараевт захиж ОХУ-аас захиж авруулж “Профессорын бүтээлийн өв”-д хэвлүүлсэн билээ.

Доктор Х.Гүндсамбуугийн 1990 онд хэвлүүлсэн “Далд эдийн засаг: тархалт, үр дагавар, тэмцэл” болон 1991 онд хэвлүүлсэн “Ажилгүйдэл: асуудал, шийдэл” гэсэн хоёр ном бий. Харагдах байдал нь бэсрэг ч хөндсөн асуудлын шинэлэг байдал, урд өмнө төдийлөн судлагдаагүй асуудлуудыг хөндөж, хөндөхөөр барахгүй нэлээд нухацтайгаар судалж, асуудал дэвшүүлснээрээ гойд сонирхолтой юм. Тус хоёр номынхоо нэрийн тодотголд, “социологийн найруулал” болон “социологийн тэмдэглэл” гэж байгаад туурвисан эдгээр бүтээлүүд нь эдийн засгийн социологийн даацтай бүтээлийн тоонд зүй ёсоор орно. Дэглэм солигдсоны дараахан, мэдээлэл хараахан нээлттэй, хүртээмжтэй болж чадаагүй байсан үе гээд төсөөлбөл тухайн үедээ хаалттай байсан хурцхан асуудлуудыг зоригтой дэлгэж, задалж чадсан байдаг. *«Эдийн засагчид, статистикчид далд эдийн засгийг төсөөлдөг мөртлөө судалдаггүй. Улс төрчид болохоор мэдэхгүй юм шиг дүр эсгэдэг атлаа түүнийг овжин ашиглах, өмч хөрөнгө, мөнгийг идэж уухдаа гаргуун»* гэж байгаад, далд эдийн засгийн шалтгаан нөхцөлийг ашиг сонирхлын зөрчил дунд нь задалж, дүгнэсэн байдаг. Зөвхөн дээрх хоёр бүтээлээр тогтохгүй хэд хэдэн цуврал нийтлэлүүд болон нийгмийн бүлэг давхрааны асуудлыг судлахдаа ч эдийн засгийн шалгуурыг байнга анзаарч шинжилсэн байдаг юм.

Түүний бичсэн “Социологийн Марксист парадигм” хэмээх цомхон боловч өвөрмөц бүтээл бий. Тус номын нэрийн тодотголд “Цуврал лекц” хэмээн бичсэн байдаг бөгөөд хэвлэлийнхээ оршилд үүнийгээ *“Сурах бичиг тэрлэх яггүй. Миний энэ цуврал лекц болохоос сурах бичиг биш”* хэмээн их л даруухан учирласан байдаг. Энэ нь марксизмын талаарх гүнзгий эргэцүүлэл, марксист онолчдын туурвисан бүтээлүүдийн далайцтай харьцуулсан шинжилгээ, Марксын Капитал, Эв хамт намын тунхагаас эхлээд сонгодог бүтээлүүдийн REVIEW, чансаатай хураанги юм. Номынхоо удиртгалд, *“Социализмын гэгдэх бидний үеийнхэн хотлоороо шахам марксистууд атлаа, маркс судлаач нь хуруу дарам”* хэмээн дурдаж байгаад *«Марксизмын ачаар манайхан эх түүх, амьдран буй нийгмээ бурхны тааллаар бус, шинжлэх ухааны үүднээс танин мэдэх үүд нээгдсэн. Өнөө цагт манайхан түүний бүтээлээс номын сангаа зайчилж байхад, өрнөдийн шилдэг сурах бичгүүдэд байраа эзэлсээр л байна»* хэмээн халаглаж байгаад *«К.Маркс бол капитализмын үүсэл хөгжил, оршин тогтнолыг хамгийн буурьтай судалсан суут эрдэмтэн», «Марксизм шиг хүн төрөлхтөнд түгэн дэлгэрсэн сургаал бараг байхгүй»* хэмээн онцолж байгаад хорь гаран лекцийг эмхэтгэн хэвлүүлсэн юм.

Лекц бүрийн төгсгөлд сэдвийн хураангуйг товчхон зангидаж, эргэцүүлэх асуултууд хийгээд мэдлэгээ шалгах сорилын асуултууд, унших эх сурвалжууд болоод эшлэлийн жагсаалтыг оруулаад зогсохгүй түлхүүр ойлголтуудыг ялгаж өгсөн нь бие даан гүнзгийрүүлэн судлахыг хүссэн хэн бүхэнд хүртээмжтэй сурах бичиг болсон төдийгүй социологийн боловсролд оруулсан үнэтэй хувь нэмэр билээ. Чухамдаа марксизмыг монголчууд олон жил судалсан ч ингэж оюутнуудад зориулж хураангуйлсан, тоймолсон, энгийн, углуургатай сонирхолтой бичсэн бүтээл өдгөө хүртэл төрөөгүй л байна. Үнэндээ англи хэл дээр ч ийм энгийн сонирхолтой бичсэн бүтээл санаанд орж ирэхгүй.

1980-аад оны сүүлээр, өөрчлөн байгуулалтын давалгаа эхэлж, тэрхүү давалгаанд, түүчээ нь биш юмаа гэхэд цээжинд нь явж, сэхээтнүүдээ манлайлж, олон асуудалд өөр өнцгөөс харж, социологичоор, шүүмжлэлт байдлаар хурц хурцхан байр сууриа илэрхийлэх болсон байдаг. Тухайн үед бичсэн өгүүлэл, нийтлэлүүдээс нь үүнийг харж болно. Тухайлбал, “Социализмын ленинч дүр төрх”, “Номенклатур анги”, “Захиран тушаах систем” зэрэг бүтээлүүдийг дурдаж болно. Улс төрийн өгүүлэлүүдээс гадна нийгмийн асуудлуудыг хөндсөн шүүмжлэлт социологич нийтлэл өгүүлүүд нь энэ үеэс эхэлнэ.

### **Намыг шинэчлэх хөдөлгөөн**

1990 оны “үймсэн олны хувьсгал” түүний амьдралд томоохон өөрчлөлт авчирсан ба МАХН-ыг шинэчлэгч арван таван эрдэмтний нэг болж онц их хурлын төлөөлөгчөөр сонгогдон, МАХН-ын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, дүрмийг шинэчлэн боловсруулж МАХН-г “дахин төрөх”-өд оролцов. Мөн элдэв цензургүй бүтээлээ туурвих боломжийг хамгийн сайн ашиглаж олон бүтээл туурвисан ясны хөдөлмөрч социологич бол Х.Гүндсамбуу байв.

Монголын социологийн түүхийг анд нөхөр С.Дашдаваагийн хамт бичсэн бөгөөд тэдний эрдмийн нөхөрлөл нь 1990 оноос улс төрийн идэвхтэй амьдрал болж хувирчээ. Ажил мэргэжил, судалгааны чиглэл, мэдээлэл боловсруулах сонирхлоороо холбогдсон, олон жил хамтран бүтээлээ туурвиж

хоршиж байсан их эрдэмтэд 1990-ээд онд улс төрийн сонирхол үзэл бодлоороо дахин нийлж хамтран зүтгэсэн байдаг.

Доктор Ц.Пүрэв дурсамждаа, *«Монголын нийгмийг шинэчлэх хөтөлбөр боловсруулах Зардыхан тэргүүтэй эрдэмтдийн багт орж, ажилласан 15 эрдэмтний нэг. Мөн энэ багт миний эрдэм шинжилгээний ажлын удирдагч асан социологич доктор С. Даидаваа бас орсон байдаг. “Нийгмийг янз бүрээр тайлбарлаад зогсохгүй түүнийг өөрчлөх гол зорилгыг” хэрэгжүүлэхэд манай социологичдын оруулсан бас нэг хувь нэмэр хэмээн хэлж болох юм»*<sup>19</sup> хэмээн тухайлан дурдсан байдаг.

### **Үнэ цэнтэй мэргэжилтэн**

1990 оны 8-р сарын 1-нээс 1991 оны 12-р сарын 31 хүртэл “Шинжээч” хоршоонд эрдэм шинжилгээний ажилтан, төслийн удирдагчаар ажиллажээ.

1992 оны 1-р сарын 1-нээс 1994 оны 4-р сарын 11 хүртэл МАХН-ын Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн төвд эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллажээ.

Мөн 1992 оны 2-р сарын 15-наас 1993 оны 9-р сар хүртэл МУИС-ийн Социологийн тэнхимд 50 хувийн багшаар хавсран ажиллаж байв.

1994 оны 4-р сарын 11-нээс 1994 оны 7-р сарын 21-ны өдөр ХАБАЯ-ны хөдөлмөрийн ерөнхий газрын ерөнхий захирлаар ажиллажээ.

Х.Гүндсамбуу нь 1994 оны 8-р сараас 1996 оны 8-р сарын 1 хүртэл УИХ-ын дэргэдэх “Судалгааны төв” байгуулагдахад “эрдэм шинжилгээний ахлах ажилтан”-аар ажиллажээ.

1996 оны 9-р сарын 15-наас 1999 оны 2-р сарын 15 хүртэл Х.Гүндсамбуу нь МУИС-ийн Социологийн тэнхимийн үндсэн багшаар ажиллаж эхэлжээ.

Улмаар 1999 оны 2-р сарын 1-наас “эрдмийн зэрэг хамгаалах” хувийн хүсэлтээр 50 хувийн багшаар ажиллажээ.

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгчээр 1999 оны 2-р сараас 2000 оны хавар хүртэл ажилласан.

2000 оны хавраас “Удирдлагын академи”-д 2006 он хүртэл багшилж байжээ.

Дээрх замналыг нэгтгээд дүгнэвэл, судлаач мэргэжилтнийхээ хувьд үнэхээр үнэ цэнтэй шилдэг мэргэжилтэн байсны хувьд, түүнийг шинэ бүтэц бий болоход, шинэ орон тоо гарах тоолонд урьж ажиллуулдаг байсан гэж хэлж болно.

Философийн Цэрэн багш Гүндээ багшийг “Хүндсамбуу” гэж нэрлэнэ. Хүндэлж авгайлж байгаа нь тэр. “Хүндсамбуугаар сонин юутай” гээд мэндлэхэд нь Гүндээ багш хариуд нь “Хүн ухаантан сайн уу” гэж хариу барина. Цэрэн багш голдуу орос хэл дээр, шинэ сонин зарим нь ч ховор хуучин номнууд үүрч явна. Тэр номноосоо хүнд гайхуулна. Хүнд байгаа номыг бас шохоорхож, гуйж явдаг, та бүхэн мэднэ дээ. Гүндээ багшид нэг удаа Бериягийн тухай номыг гайхуулаад орхиж. Тэгсэн Гүндээ багш гуйж аваад, нэг хэсгийг нь төдхөн орчуулаад “Миний аав Лавренти Берия” гээд ном гаргачхаж билээ. Өөрөөр хэлбэл, Гүндээ багшийн сонирхлыг татаад орхивол дорхноо эргэцүүлэн боловсруулж, эсхүл шохоорхон орчуулаад бүтээл болгоод гаргачихдаг, тийм мэдрэг, тийм соргог, тийм бүтээлч эрдэмтэн байлаа.

\*\*\*

1967 онд МХЗЭ-ийн гишүүн, 1969 онд МҮЭ-ийн гишүүнээр элссэн. 1981 оны 11-р сард МАХН-д элссэн. 1990 оны МАХН-ын “Онц их хурал”-д төлөөлөгчөөр оролцсон, 1992 онд Улаанбаатар хотын МАХН-ын хорооны “Тэргүүлэгч гишүүн”-ээр сонгогдсон.

МАХН-ын бүлгийн ахлах зөвлөх Х.Гүндсамбуу Сүхбаатар аймгийн 31-р тойрогт МАХН-аас УИХ-ын сонгуульд өрсөлдөж байсан. (УИХ-ын 1996 оны сонгуульд нэр дэвшигчид, 1996).

Х.Гүндсамбуу нь таван хүү, хоёр охинтой.

<sup>19</sup> Ц.Пүрэв, “Социологич нөхдөө эргэн дурсахад”, МУИС-ийн Социологийн тэнхимийн 30 жилийн ойд зориулж бичсэн дурсамж.